



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 90

Мандалговь

Хөрөнгө акталж худалдах тухай

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2 дах хэсгийн 77.2.3 дахь заалт, 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1 дэх заалт, 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

Нэг: Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2007 онд ашиглалтанд орсон 27,022,416.89 /хорин долоон сая хорин хоёр мянга дөрвөн зуун арван зургаан төгрөг наян есөн/ мөнгөний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ДУА 39-99 улсын дугаартай Прадо-70 маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 5,000,000 /таван сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга /Б.Оюунчимэг/-т даалгасугай.

Дөрөв: Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

